

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ

АУДИТЫН КОД: ТӨА-2025/27-17-ШТА-ГА

Зуунмод 2025 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Ахлах аудитор Л.Жаргалсайхан

Утас: 70273465 Цахим хаяг: jargalsaikhanl@audit.gov.mn

Аудитор Г.Сугармаа

Утас: 70272582 Цахим хаяг: sugarmaag@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

**АГУУЛГА**

Товчилсон үгийн тайлбар.....	2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	3

БҮЛЭГ А. ХҮҮ БОЛОН ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТ НЬ ӨМНӨХ ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛД ТУЛГУУРЛАН ХИЙГДЭЖ БАЙНА.....5

А.1. Хүүгийн орлогыг дамжуулан зээлдүүлэх гэрээнд үндэслэн төлөвлөж байгаа бол торгуулийн орлогыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд төлөвлөж байна.....5

А.2. Хүү, торгуулийн орлогыг өмнөх жилүүдийн гүйцэтгэлд тулгуурлан төлөвлөсөн байна.....5

А.3. Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль болон холбогдох бусад хууль эрх зүйн актуудад дүн шинжилгээ хийж бодит байдалд нийцэхгүй зарим зүйл, заалтыг сайжруулах шаардлага байна.....8

БҮЛЭГ Б. ТОРГУУЛИЙН ОРЛОГО НЬ ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО БАЙХААР ХУУЛЬЧИЛСАН Ч ЗАРИМ ОРЛОГЫГ УЛСЫН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН БАЙНА.....11

Б.1. Тайлант онуудад торгуулийн орлогын төлөвлөгөө давж биелсэн ч тухайн онд ногдуулсан торгуулийн орлогыг төсөвт бүрэн төвлөрүүлээгүй байна.....11

Б.2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд торгуулийн орлогыг хуваарилахдаа хуульд заасан хувь хэмжээг баримтлаагүй байна.....15

БҮЛЭГ В. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН ЗАРЦУУЛАЛТЫГ ЗӨВХӨН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛААР ҮНЭЛЖ, ДҮГНЭХ БОЛОМЖГҮЙ БАЙНА.....17

В.1. Торгуулийн орлогын тодорхой хувийг ГХУСАХЗ-д баталж, зарцуулж байна.....17

В.2. Хүү, торгуулийн орлогын зарцуулалтыг ил тод мэдээлж байна уу? Торгуулийн орлогын зарцуулалтыг шилэн дансны нэгдсэн системээр дамжуулан олон нийтэд ил тод мэдээлж байна.....22

БҮЛЭГ Г.ТОРГУУЛЬ НОГДУУЛАХ ЭРХ БҮХИЙ ИХЭНХ БАЙГУУЛЛАГУУДАД МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН БАЙХГҮЙГЭЭС, ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ХҮНДРЭЛТЭЙ БАЙНА.....22

Г.1. Торгуулийн орлого бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сан хангалтгүй байна.....22

Г.2. Торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт хэрэгжүүлэх механизм байхгүй байна.....23

ДҮГНЭЛТ:.....26

ЗӨВЛӨМЖ:.....27

Холбогдох байгууллагын санал:.....28

Хүснэгтийн товчье

Хүснэгт 1: Хүү торгуулийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл.....5

Хүснэгт 2: Сүүлийн 4 жилийн хүү, торгуулийн орлогын төлөвлөгөө.....6

Хүснэгт 3: Торгуулийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл.....7

Хүснэгт 4: Торгуулийн орлогыг төвлөрүүлсэн байгууллага.....11

Хүснэгт 5: ЭБАТ-ны ногдуулсан торгуулийн орлогын нэгтгэсэн судалгаа.....12

Хүснэгт 6: Аймгийн Цагдаагийн газрын торгуулийн орлого.....13

Хүснэгт 7: Аймгийн ТЕЗ-ийн 2023-2024 оны хүү, торгуулийн орлогын төсвийн гүйцэтгэлийн тайлангийн зөрүү.....13

Хүснэгт 8: Аймгийн нийт орлого, татварын бус орлогын дүнд торгуулийн орлогын эзлэх дүн.....15

Хүснэгт 9: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зардлын төлөвлөлтийн байдал.....16

Хүснэгт 10: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл.....17

Хүснэгт 11: ГХУСАХЗ-ын зарцуулалт.....18

Хүснэгт 12: Дутуу хэрэгжсэн болон хэрэгжээгүй арга хэмжээ.....19

Хүснэгт 13: Дутуу хэрэгжсэн болон хэрэгжээгүй арга хэмжээ.....20

Хүснэгт 14: Торгуулийн орлогыг дутуу төвлөрүүлсэн байдал.....23

Хүснэгт 15: Зөрчлийн хэргийг шүүхээр хянан шийдвэрлэсэн судалгаа.....24



Товчилсон үгийн тайлбар

ААН	Аж ахуйн нэгж
АЗБХГ	Агаарын замын боомт хариуцсан газар
БОГ	Байгаль орчны газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ГИХГ	Гадаадын иргэн харьяатын газар
ГХУСАЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зардал
ГХУСАХЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга, хэмжээний зардал
ГХУСАЗСЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
МЭЕГ	Мал эмнэлгийн ерөнхий газар
МЭГ	Мал эмнэлгийн газар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОБГ	Онцгой байдлын газар
СХЗХ	Салбарын хяналт зохицуулалтын хэлтэс
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
УБХ	Улсын бүртгэлийн хэлтэс
ХХААГ	Хүнс хөдөө аж ахуйн газар
ХХҮГ	Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар
ЭБАТ	Эрх бүхий албан тушаалтан
ЭМГ	Эрүүл мэндийн газар



Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Монгол Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны “Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө батлах тухай” А/108 дугаар тушаал, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт

Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг аймгийн ИТХ, Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэсэн.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Хүү, торгуулийн орлогын төлөвлөлт нь хэрэгцээ шаардлагад нийцсэн эсэх;
- Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлтийг хууль, журамд нийцүүлэн төвлөрүүлсэн эсэх;
- Хүү, торгуулийн орлогын зарцуулалт үр дүнтэй эсэх;
- Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналт үр дүнтэй хэрэгжсэн эсэх.

Аудитын хамарсан хүрээ

Аудитад хүү, торгуулийн орлого төлөвлөх, бүрдүүлэх, зарцуулах, хяналт хэрэгжүүлдэг төрийн байгууллагуудын холбогдох чиг үүргийн хэрэгжилт, 2023, 2024 онд хүү, торгуулийн орлогыг бүрдүүлсэн байдал, зарцуулалт, хяналт хэрэгжүүлэх холбоотой тайлан мэдээ, дансны хуулга, бусад нотлох баримт, материалыг хамрууллаа.

Аудитын хязгаарлалт

Байхгүй.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа.

- Нийслэл дэх Төрийн аудитын газрын Дарга, тэргүүлэх аудиторын баталсан “Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт” гүйцэтгэлийн аудитын төлөвлөгөөнд тусгагдсан шалгуур үзүүлэлтүүд
- Аймаг, сумдын 2023, 2024 оны төсөв баталсан ИТХ-ын тогтоолууд
- Бусад холбогдох хууль, тогтоомж, эрх зүйн актууд.



**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал удирдаж, аудитын менежер О.Амаржаргал чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Л.Жаргалсайхан, аудитор Г.Сугармаа нар гүйцэтгэв.

Аудитын талбарын ажлыг 2025 оны 4 дугаар сарын 30-ны өдрөөс 2025 оны 8 дугаар сарын 01-ний өдөр хүртэл гүйцэтгэж, аудитын тайлан, судалгааг 2025 оны 8 дугаар сарын 07-ны өдөр Нийслэл дэх Төрийн аудитын газарт хүргүүллээ.

Хүндрэл бэрхшээл



А. ХҮҮ БОЛОН ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТ НЬ ӨМНӨХ ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛД ТУЛГУУРЛАН ХИЙГДЭЖ БАЙНА.

А.1. Хүүгийн орлогыг дамжуулан зээлдүүлэх гэрээнд үндэслэн төлөвлөж байгаа бол торгуулийн орлогыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд төлөвлөж байна.

А.1.1. Аймгийн 2023, 2024 оны төсөв баталсан ИТХ-ын тогтоолд хүүгийн орлогыг тусад нь төлөвлөөгүй, хүү торгуулийн орлого гэсэн үзүүлэлтээр нийт дүнгээр нь төлөвлөсөн байна. Аймгийн дэд бүтцийг хөгжүүлэх, нийтийн аж ахуйн чиглэлээр авсан дамжуулах зээлдүүлэх OL-1847 MON-11 OL-2301 MON-11 гэрээний дагуу төлөх зээл, хүүгийн төлбөрт 2023 онд 224.4 сая, 2024 онд 20.5 сая төгрөг төлөвлөжээ. Хүүгийн орлого төлөвлөсөн хэдий ч Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023, 2024 онуудын төсвийн гүйцэтгэлийн тайланд хүүгийн орлого /120002/ дансанд төлөвлөгөө гүйцэтгэлийг тусгаагүй, торгуулийн орлого /120003/ дансаар торгуулийн орлоготой нийлүүлэн тайлагнасан байна.

Азийн хөгжлийн банк, Дэлхийн банкт байгуулсан Засгийн газрын дамжуулан зээлдүүлэх зээл, зээлийн гэрээ нь хүүгийн орлогыг төлөвлөх шаардлагыг бий болгосон байна.

А.1.2. Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-д “татварын бус орлого нь ..., торгуулийн орлого, хууль тогтоомжийн дагуу төсөвт төвлөрүүлэх бусад орлогоос бүрдэнэ” гэж заасан. Мөн түүнчлэн Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-д “... торгуулийн орлогын 40-өөс доошгүй хувийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр дараа жилийн төсөвт тусгаж, санхүүжүүлнэ”, Авто замын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2-д “Нийслэл, орон нутгийн чанартай авто замын сангийн хөрөнгө дараах эх үүсвэрээс бүрдэнэ: 25.2.4 нийслэл, орон нутгийн авто зам дээр хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргасан, авто замын талаарх хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгууль” гэж заасан.

Мөн Сангийн сайд 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журмын 7 дугаар зүйлийн 7.5.1.а-д “аймаг, нийслэлийн төсвийн нийт орлогын дүнг Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан орлогын нэр, төрлөөр; 7.6.1.а сум, дүүргийн төсвийн нийт орлогын дүнг Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан орлогын нэр, төрлөөр” гэж заажээ.

Эдгээр хууль болон журмыг хэрэгжүүлэн торгуулийн орлогыг төлөвлөсөн байна.

А.2. Хүү, торгуулийн орлогыг өмнөх жилүүдийн гүйцэтгэлд тулгуурлан төлөвлөсөн байна.

А.2.1. Төв аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021-2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаар торгуулийн орлогын төлөвлөгөө, биелэлт дараах байдалтай байна.

Хүснэгт 1: Хүү торгуулийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

(сая.төгрөг)

Он	Үзүүлэлт	Сумдын дүн	Аймгийн дүн	Нийт дүн
2021	Төлөвлөгөө	1,207.70	600	1,807.70
	Гүйцэтгэл	1,630.30	2,594.00	4,224.40
	Зөрүү	422.6	1,994.00	2,416.70
2022	Төлөвлөгөө	1,353.50	600	1,953.50



2023	Гүйцэтгэл	1,158.60	1,430.30	2,588.90
	Зөрүү	-194.9	830.3	635.4
	Төлөвлөгөө	1,760.50	947.4	2,707.90
	Гүйцэтгэл	1,816.70	1,631.20	3,447.80
	Зөрүү	56.2	683.8	739.9
	Төлөвлөгөө	2,374.20	1,270.50	3,644.70
2024	Гүйцэтгэл	3,065.10	1,810.10	4,875.20
	Зөрүү	690.9	539.6	1,230.50
	Төлөвлөгөө	2,374.20	1,270.50	3,644.70

Эх сурвалж: ТЭЗ-ийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Нийт дүнгээр нь авч үзвэл аймгийн хэмжээгээр сүүлийн 4 жилд хүү, торгуулийн орлого давж биелсэн байна. Сумдын торгуулийн орлогын хэмжээ 2022 онд 194.9 сая төгрөгөөр төгрөгөөр тасарч бусад онуудад аймгийн төвлөрсөн болон сумдын орлого давж биелжээ. Хэдийгээр нийт дүнгээрээ давж биелсэн ч зарим сумдын торгуулийн орлогын төлөвлөгөө тасарсан байна. Тухайлбал:

- 2021 онд Архуст, Баянжаргалан, Баянцагаан, Бүрэн, Дэлгэрхаан, Өндөрширээт зэрэг сумдын төлөвлөгөө 0.3-15.3 сая төгрөгөөр,
- 2022 онд нийт 17 сумын орлогын төлөвлөгөө 0.2-61.4 сая төгрөгөөр /Баян-Өнжүүл сум 0.2 сая, Лүн сум 61.4 сая/,
- 2023 онд нийт 12 сумын орлогын төлөвлөгөө 0.04-200.3 сая төгрөгөөр, /Бүрэн сум 0.04 сая, Зуунмод сум 200.3 сая/,
- 2024 онд Баяндэлгэр, Баянцагаан, Заамар, Мөнгөнморьт, Угтаалцайдам, Цээл зэрэг сумдын төлөвлөгөө 4.2-68.3 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

А.2.2. Торгуулийн орлогыг урьдчилсан тооцох боломжгүй учраас аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс нь торгуулийн орлогыг өмнөх жилүүдийн гүйцэтгэлд тулгуурлан төлөвлөж, Сангийн яам жил бүр хянаж ирсэн байна.

Хүснэгт 2: Сүүлийн 4 жилийн хүү, торгуулийн орлогын төлөвлөгөө

(мянган.төгрөг)

Он	2021	2022	2023	2024
ИТХ-р анх баталсан	0	1,826,700.0	2,024,393	3,020,514.0
ИТХ-р тодотголоор баталсан	1,807,700.0	1,953,500.0	2,707,897.4	3,644,743.4
Зөрүү	-	126,800.0	683,504.1	624,229.4

Эх сурвалж: ИТХ-ын төсөв баталсан тогтоол

Төв аймгийн тухайд торгуулийн орлогын хэмжээ жил бүр өсөн нэмэгдэж байгаа бөгөөд орлого төлөвлөхдөө өмнөх оны гүйцэтгэлд тулгуурлахаас гадна төсвийн тодотгол батлахдаа тухайн жилийн орлогын гүйцэтгэлийг үндэслэн нэмэгдүүлэн төлөвлөсөн байна. Тухайлбал, 2022-2024 онуудад 1,434.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөжээ. Мөн түүнчлэн 2024 онд Сангийн яамнаас торгуулийн орлогын дүнг 2,020.5 мянган төгрөгөөр хянаж ирүүлснийг аймгийн ИТХ-р батлахдаа 1,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 3,020.5 сая төгрөгөөр баталжээ.

А.2.4. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, Авто замын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.4-т заасны дагуу торгуулийн орлогоос ГХУСЗ, авто замын сангийн зардлыг төлөвлөж байна. Өмнөх онуудын торгуулийн орлогыг шүүхээс тогтоосон торгох ял, Зөрчлийн хуулийн цагдаагийн байгууллагатай холбоотой торгууль гэж нарийвчлан ялгадаггүй,



торгуулийг орлогыг төлөвлөх боломжгүй зэргээс Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж, ГХУСАХЗ-ыг төлөвлөхөд хүндрэлтэй байдаг байна.

Аймгийн ИТХ-ын 2023 ажлын албаны зардалд 180.0 сая төгрөг, сумдын ИТХ-ын зардалд 137.5 сая төгрөг, нийт 317.5 сая төгрөг, 2024 оны ИТХ-ын ажлын албаны зардалд 180.0 сая төгрөг, сумдын ИТХ-ын зардалд 289.4 сая төгрөг, нийт 469.4 сая төгрөгийг аймаг, сумдын ГХУСЗ-д баталсан байна.

Аймгийн авто замын санд 2023 онд 1,200.0 сая төгрөг, 2024 онд 1,500.0 сая төгрөг тус тус баталжээ.

А.2.5. Аймгийн хэмжээгээр торгуулийн орлогын төлөвлөгөө сүүлийн хоёр жил давж биелсэн байна.

Хүснэгт 3: Торгуулийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

(мянган.төгрөг)

№	Сум	2023 он			2024 он		
		төлөвлөгөө	гүйцэтгэл	Зөрүү	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү
1	Аргалант	23,000.0	40,022.5	17,022.5	64,000.0	106,384.5	42,384.5
2	Алтанбулаг	3,000.0	5,705.0	2,705.0	3,000.0	15,758.8	12,758.8
3	Архуст	600.0	715.0	115.0	600.0	4,058.7	3,458.7
4	Батсүмбэр	20,000.0	22,278.4	2,278.4	20,000.0	31,230.3	11,230.3
5	Баян	35,000.0	52,101.3	17,101.3	35,000.0	74,007.5	39,007.5
6	Баяндэлгэр	13,000.0	2,748.2	(10,251.8)	9,200.0	3,112.0	(6,088.0)
7	Баянжаргалан	1,200.0	2,079.2	879.2	1,200.0	4,116.4	2,916.4
8	Баян-Өнжүүл	11,600.0	12,754.9	1,154.9	11,600.0	12,655.0	1,055.0
9	Баянхангай	60,500.0	50,189.5	(10,310.5)	160,500.0	194,666.6	34,166.6
10	Баянцагаан	15,000.0	100,460.0	85,460.0	233,000.0	164,694.9	(68,305.1)
11	Баянцогт	10,000.0	6,896.5	(3,103.5)	10,000.0	26,350.1	16,350.1
12	Баянчандмань	300,000.0	338,602.1	38,602.1	322,729.4	554,592.9	231,863.5
13	Борнуур	60,000.0	38,962.0	(21,038.0)	71,000.0	101,512.2	30,512.2
14	Бүрэн	400.0	355.0	(45.0)	400.0	5,295.8	4,895.8
15	Дэлгэрхаан	900.0	-	(900.0)	900.0	993.0	93.0
16	Жаргалант	30,000.0	32,275.8	2,275.8	30,000.0	30,777.6	777.6
17	Заамар	90,000.0	70,065.4	(19,934.6)	90,000.0	83,760.4	(6,239.6)
18	Зуунмод	510,000.0	309,673.5	(200,326.5)	500,000.0	634,863.7	134,863.7
19	Лүн	350,000.0	382,768.3	32,768.3	500,000.0	530,547.8	30,547.8
20	Мөнгөнморьт	19,000.0	49,014.1	30,014.1	10,000.0	5,265.0	(4,735.0)
21	Өндөрширээт	1,900.0	2,295.0	395.0	1,900.0	3,735.0	1,835.0
22	Сүмбэр	12,600.0	6,668.4	(5,931.6)	12,600.0	430.0	(12,170.0)
23	Сэргэлэн	50,000.0	137,494.9	87,494.9	70,000.0	171,809.2	101,809.2
24	Угтаал	9,000.0	4,684.0	(4,316.0)	9,000.0	5,573.0	(3,427.0)
25	Цээл	7,500.0	4,437.8	(3,062.2)	7,000.0	2,752.6	(4,247.4)
26	Эрдэнэ	76,300.0	95,504.0	19,204.0	150,600.0	169,008.8	18,408.8
27	Эрдэнэсант	50,000.0	47,903.3	(2,096.7)	50,000.0	127,148.6	77,148.6
	Сумын дүн	1,760,500	1,816,654		2,374,229	3,065,100	690,871
28	Аймаг	947,397.4	1,631,165.3	683,767.9	1,270,514.0	1,810,093.9	539.6
	Нийт дүн	2,707,897	3,447,820		3,644,743	4,875,194	

Эх сурвалж: Төсөв баталсан тогтоол, Санхүүгийн тайлан

Нийт дүнгээр орлогын төлөвлөгөө давж биелсэн хэдий ч 2023 онд Баяндэлгэр, Баянхангай, Баянцогт, Борнуур, Дэлгэрхаан, Заамар, Зуунмод,



Сүмбэр, Угтаал, Цээл, Эрдэнэсант зэрэг сумд, 2024 онд Баяндэлгэр, Баянцагаан, Заамар, Мөнгөнморьт, Сүмбэр, Угтаал, Цээл зэрэг сумдын торгуулийн орлогын төлөвлөгөө биелээгүй байна. Аймгийн төвлөрсөн төсвийн торгуулийн орлого 539.6-683.8 сая төгрөгөөр давж биелсэн байна.

Сумдын хувьд торгуулийн орлогын төлөвлөгөөний хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж үнэлэлт дүгнэлт өгөх ажил хийгдээгүй байна. Аймгийн төвлөрсөн төсвийн хувьд сар, улирлын төсвийн орлогын мэдээнд дүн шинжилгээ хийн ажиллаж иржээ. Тухайлбал, торгуулийн орлогын төлөвлөгөөний биелэлт, орлого давсан нь ГИХГ-ын АЗБХГ-ын торгууль аймагт ордог болсон, мөн цагдаагийн байгууллагаас зохион байгуулсан аян, арга хэмжээ зэрэг нь орлогын төлөвлөгөө давж биелэхэд нөлөөлсөн гэсэн дүгнэлт хийсэн байна.

А.2.6. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5-т “хяналт шалгалтын байгууллага улсын болон орон нутгийн төсөвт орлого оруулах үүрэг хүлээхгүй” гэж заасан. Цагдаагийн байгууллага, татварын байгууллагын торгуулийн орлогыг төлөвлөх боломжтой хэдий ч нийтэд нь өмнөх онуудын гүйцэтгэлд үндэслэн төлөвлөж байна. Өмнөх онуудын торгуулийн орлого бүрдүүлсэн байгууллагууд, тэдгээрийн ЭБАТ-ны тавьсан торгууль, акт, алданги, хохирол нөхөн барагдуулалт зэргийг тооцсон, судалгаа гаргаж төсвийн төлөвлөлтөд ашигласан зүйл байхгүй байна.

А.3. Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль болон холбогдох бусад хууль эрх зүйн актуудад дүн шинжилгээ хийж бодит байдалд нийцэхгүй зарим зүйл, заалтыг сайжруулах шаардлага байна.

А.3.1. Торгуулийн орлого бүрдүүлэлттэй холбоотой эрх зүйн актууд нь Төсвийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авто замын тухай хууль зэрэг хуулиудаас гадна салбарын хууль, тогтоомжоос бүрдэж байна. Эрх зүйн актууд нь харилцан уялдаатай, хэрэгцээ шаардлага хангасан эсэхийг дээрх хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж буй аймгийн ЗДТГ-ын СХЗХ, Цагдаагийн газар, Татварын газар, ЭМГ, ХХҮГ, ХХААГ, МЭГ, ГИХГ-ын АЗБХГ, УБХ, ГХБХБГ зэрэг байгууллагуудын холбогдох ЭБАТ-тай уулзалт, ярилцлага хийж тодруулахад асуудлууд гарч байна. Тухайлбал:

- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.52, 5.53 дахь заалтад 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр нэмэлт оруулахдаа хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч нь Зөрчлийн хуулийн 10.15 дугаар зүйл /Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль зөрчих/, хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч нь Зөрчлийн хуулийн 10.16 дугаар зүйл /Хөдөлмөрийн тухай хууль зөрчих/ гэсэн зөрчлийг хянаж шийдвэрлэхээр заажээ. Өөрөөр хэлбэл хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч нь Хөдөлмөрийн тухай хууль зөрчсөн зөрчлийг, хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль зөрчсөн зөрчлийг хянаж шийдвэрлэхээр болсон байна. Төв аймагт хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчийн орон тоо нөхөгдөөгүйгээс Хөдөлмөрийн тухай хууль зөрчсөн зөрчлийг хянаж шийдвэрлэх боломжгүй болсон байна.
- Зөрчлийн тухай хуулийн Татварын хууль зөрчих гэсэн 11.19 дүгээр зүйлийн 2.6-д “Монгол Улсын стандартын шаардлага хангасан кассын машин, хэвлэх төхөөрөмж, хэвлэлийн хор, төлбөрийн баримтын цаас, пос терминал машин хэрэглэх” гэж заасан. Гэтэл татвар төлөгч хүн, хуулийн этгээд нь цахим



төхөөрөмж, хэрэгсэл, сошиал сүлжээг өргөн ашиглаж НӨАТ-ын баримт олгож байгаа тул энэ заалтыг хэрэгжүүлэх боломжгүй байдаг байна.

- Зөрчлийн тухай хуулийн Татварын хууль зөрчих гэсэн 11.19 дүгээр зүйлийн 10-д “Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварыг хуульд заасан хугацаанд төлөөгүй бол төлбөл зохих татварыг нөхөн төлүүлж, хүнийг нөхөн төлүүлэх татварын 10 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж заасан. Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн эзэмшигчийн тоо олон шилжилт хөдөлгөөн их хийгддэг боловч хасалт хийгддэггүй, хэнийг торгох нь тодорхойгүй байдгаас энэ заалт хэрэгжихгүй байна.
- Зөрчлийн тухай хуулийн Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хууль зөрчих гэсэн 13.10 дугаар зүйлийн 4.1-д “жороор олгох эмийг жоргүйгээр олгосон”, 4.2-д “эмийг хүчингүй жороор олгосон бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж заасан боловч улсын хэмжээнд жороор олгох малын эмийн жагсаалт батлагдаагүй байна.

А.3.3. Холбогдох ЭБАТ-аас торгуулийн хариуцлага тооцоход үндэслэдэг Зөрчлийн тухай хууль болон бусад хуулиудад тодорхойгүй маргаантай заалтууд байдаг эсэх талаар тодруулахад дараах асуудал гарч байна. Үүнд:

- Зөрчлийн тухай хуулийн Татварын хууль зөрчих гэсэн 11.19 дүгээр зүйлийн 8.3.энэ хуулийн 8.1, 8.2-т заасан “өмнөх тайлант сарын хугацаанд олсон орлогыг тодорхойлох боломжгүй бол төлбөрийн баримт олгоогүй, эсхүл төлбөрийн баримтыг борлуулалтын үнийн дүнгээс зөрүүтэй олгосон хүнийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж заасан. Борлуулалтын орлого нь тодорхой бус иргэн гэдэг нь тогтмол бус үйл ажиллагаа явуулдаг жижиг худалдаа эрхлэгчид байдаг тул 1.5 сая төгрөгөөр торгох заалтыг хэрэгжүүлэхэд боломжгүй болдог байна.
- Зөрчлийн тухай хуулийн Газрын тухай хууль зөрчих гэсэн 8.1 дүгээр зүйлийн 10 дугаар хэсэгт “эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр газар ашигласан, улсын тусгай хэрэгцээний газарт дур мэдэн үйл ажиллагаа явуулсан, газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу эзэмшүүлэхээр зааснаас бусад газарт газар эзэмшсэн гэхчлэн зөрчилд учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж заасан. Гэтэл газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа дууссан сунгуулаагүй тохиолдолд энэ заалтаар торгохоор болдог нь хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байдаг байна.
- Зөрчлийн тухай хуулийн Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль зөрчих гэсэн 13.9 дүгээр зүйлийн 6.2-д “мэргэжлийн үйлчилгээ эрхлэх итгэмжлэлгүй этгээд, мэргэжлийн үнэмлэхгүй техникийн ажилтнаар мал эмнэлгийн үйлчилгээг гүйцэтгүүлсэн бол учруулсан хохирол нөхөн төлбөрийг гаргуулж хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж заасан хэдий ч үйлчилгээ гэдгийг /угаалга, туулга, вакцин г.м/ яаж ойлгох нь тодорхойгүй байдгаас хэрэглэх боломжгүй байна.

А.3.4. Торгуулийн хэмжээ нь үйлдсэн зөрчилтэй нь нийцдэг эсэхийг ЭБАТ-тай хийсэн ярилцлагаар тодруулахад дараах асуудлуудыг гарган тавьж байна. Үүнд:

- Аймгийн УБХ-ын Хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн Иргэний улсын бүртгэлийн тухай хууль зөрчих гэсэн 15.24 дүгээр зүйлд зааснаар хүнийг 20.0-30.0 мянган төгрөгөөр торгодог, гэтэл жил бүр энэ төрлийн



зөрчлийн тоо хэмжээ өсөж байгаа нь торгуулийн арга хэмжээ хариуцлагын хөшүүрэг болж чадахгүй байх магадлалтай,

- ГХИГ-ын АЗБХГ-ын улсын ахлах байцаагч Зөрчлийн тухай хуулийн 16.2 дугаар зүйл "Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль зөрчих"-д зааснаар ногдуулж буй торгуулийн мөнгөн дүн нь бусад улс оронтой харьцуулахад харьцангуй бага байдаг,
- Аймгийн ЗДТГ-ын СХЗХ-ийн авто тээврийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн хуулийн Автотээврийн тухай хууль зөрчих гэсэн 14.6 дугаар зүйлийн 5 дугаар хэсэгт техникийн үзлэгт ороогүй тээврийн хэрэгслийг хөдөлгөөнд оролцуулахад 20.0 мянган төгрөгөөр торгодог, энэ нь хэт бага байгаа бөгөөд хариуцлагын хөшүүрэг болж чаддаггүй,
- Аймгийн ЗДТГ-ын СХЗХ-ийн мэдээлэл, харилцаа холбооны хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн Харилцаа холбооны тухай хууль зөрчих гэсэн 14.1 дүгээр зүйлийн 7, 8-д заасан зөрчилд хуулийн этгээдийг 300.0 мянган төгрөгөөр торгодог нь аж ахуйн нэгжийн хувьд бага торгууль байдаг,
- Аймгийн МЭГ-ын мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль зөрчих гэсэн 13.9 дүгээр зүйлийн 2-д "мал эмнэлгийн холбогдолтой журам, заавар зөрчсөний улмаас өвчин тархаах, малын гаралтай хүнсний болон хүнсний бус түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдал алдагдах, мал, амьтныг тарчлаан зовоох нөхцөл байдал үүссэн бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно" гэж заасан үйлдсэн зөрчилтэй нь нийцэхгүй байдаг,
- Аймгийн Татварын хэлтсийн Захиргаа хуулийн тасгийн дарга, татварын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн Татварын хууль зөрчих гэсэн 11.19 дүгээр зүйлийн 8.3-д заасан жижиг гар дээрээс худалдаа эрхлэгчийг НӨАТ-ын баримт өгөөгүй зөрчилд 1,500.0 мянган төгрөгөөр торгох нь хэтэрхий өндөр, борлуулсан бараа бүтээгдэхүүний үнээс ч илүү гардаг,
- Аймгийн ГХБХБГ-ын газар, геодези, зураг зүйн хяналтын улсын байцаагч, газар эзэмших эрхийн хугацаа дууссан сунгалт хийлгээгүй тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн Газрын тухай хууль зөрчих гэсэн 8.1 дүгээр зүйлийн 10 дугаар хэсэгт зааснаар 500.0 мянган төгрөгөөр торгохоор байгаа нь гаргасан зөрчилтэй нь харьцуулахад өндөр байдаг гэсэн санал тус тус гаргасан. Аудитад хамрагдсан бусад ЭБАТ-ууд торгуулийн хэмжээ нь үйлдсэн зөрчилтэй нийцдэг гэсэн хариулт өгсөн.

Эндээс харахад Зөрчлийн хуулийн зарим зүйл, заалт нь үйлдсэн зөрчилтэй нийцэхгүй тохиолдол байна. Зарим нь зөрчлийн шинж чанараас хэт бага хариуцлага тогтоосноор үр дүнтэй хөшүүрэг болж чадахгүй байгаа бол, харин нөгөө хэсэг нь хэт өндөр хариуцлага зааснаас хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдал үүсэж болзошгүй байна. Иймд холбогдох байгууллага зөрчлийн шинж байдал, үр дагаварт нарийвчилсан судалгаа хийж, хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар анхаарах шаардлагатай байна.

А.3.5. Аудитын явцад ЭБАТ-уудын зөрчлийн хэргийн баримт, материалтай танилцаж, ярилцлага хийх замаар хуулийн хэрэглээ нь нийтэд адил тэгш үйлчилж байгаа эсэхийг тодруулахыг зорилоо.

Цагдаагийн байгууллага, Татварын газар, УБХ, ГИХГ-ын АЗБХГ зэргийн ЭБАТ-ууд гарсан зөрчил бүрд хариуцлага тооцон ажилласан байна. Өөрөөр хэлбэл хууль бүх нийтэд тэгш үйлчилсэн гэж үзэж болохоор байна.



Харин хуучин МХГ харьяанд байгаад салбарын байгууллагуудад шилжин ажиллаж байгаа ЭБАТ-уудын хувьд шилжин очсон байгууллагад нь хяналт шалгалтын зардал батлаагүйгээс тухайн чиглэлийн зөрчил бүрд хүрч ажиллахад хүндрэлтэй байдаг байна.

А.3.6. Зөрчлийн хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуультай холбоотой тайлангийн 3.1, 3.3, 3.4-д тусгасан тодорхой асуудлыг судлан үзэж эрх зүйн шинэчлэл, сайжруулалт хийх хэрэгцээ, шаардлага байна.

А.3.7. Аудитаар Зөрчлийн тухай хуулийн дагуу ногдуулсан торгуулийг тогтоосон хугацаанд төлөөгүй тохиолдолд Шүүхэд шилжүүлж, улмаар шийдвэр гарч төлүүлсэн тохиолдол байгаа хэдий ч иргэний өмчийн халдашгүй байдалтай зөрчилдсөн, өмч хөрөнгө хураасан асуудал аудитын хамрах хугацаа буюу 2023, 2024 онуудад гараагүй байна.

БҮЛЭГ Б. ТОРГУУЛИЙН ОРЛОГО НЬ ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО БАЙХААР ХУУЛЬЧИЛСАН Ч ЗАРИМ ОРЛОГЫГ УЛСЫН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН БАЙНА.

Б.1. Тайлант онуудад торгуулийн орлогын төлөвлөгөө давж биелсэн ч тухайн онд ногдуулсан торгуулийн орлогыг төсөвт бүрэн төвлөрүүлээгүй байна

Б.1.1. Аймгийн хэмжээнд 2023 онд торгуулийн орлогоос 2,707.9 сая төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр 3,447.8 сая төгрөг төвлөрч, төлөвлөсөн хэмжээнээс 27.3 хувиар давсан байна. Торгуулийн орлогыг 2024 онд 3,741.4 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 4,875.2 сая төгрөг төвлөрсөн нь 30.3 хувиар давж биелжээ.

Хүснэгт 4: Торгуулийн орлогыг төвлөрүүлсэн байгууллага

(сая.төгрөг)

№	Торгууль ногдуулсан байгууллага	Төвлөрүүлсэн дүн	
		2023 он	2024 он
1	Цагдаагийн газар	2,165.6	2,693.9
2	Татвар	370.4	692.1
3	Гадаадын иргэн, харьяатын газрын Хөшгийн хөндийн агаарын замын боомт хариуцсан газар	72.4	154.2
4	Төв аймаг дахь Төрийн аудитын газар, Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	442.6	755.5
5	Улсын бүртгэлийн хэлтэс	15.7	15.9
6	Байгаль орчны газар	52.4	36.8
7	Аймгийн ЗДТГ-СХЗХ	48.4	137.7
8	Онцгой байдлын газар	1.2	8.6
9	Шүүхийн шийдвэр	217.0	332.2
10	Бусад	62.1	48.3
Нийт		3,447.8	4,875.2

Эх сурвалж: Аудитын ажлын баримт

Төсвийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т “Орон нутгийн төсөвт хуваарилах орлогын нэр төрлийг энэ хуулиар...” гэж, мөн 23 дугаар зүйлийн 23.7.2, 23.9.2-т “... хүү, торгуулийн орлого”-ыг аймаг, сумын татварын бус орлого байхаар хуульчилсан байхад салбарын яам, ерөнхий газрын албан бичгүүдээр “...Монгол улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 469 дүгээр тогтоолын дагуу салбарын хяналт шалгалтын үйл ажиллагаа хэрэгжүүлэх чиг үүрэг нь харьяалагдах яамдад шилжсэнтэй холбоотойгоор чиглэлийн зөрчилд ногдуулсан төлбөрийн орлогыг улсын төсвийн 100900000602-Хяналт шалгалтын



орлого дансанд төвлөрүүлэх..." чиглэл өгсний дагуу Төв аймгийн Хүнс, хөдөө, аж ахуйн газар, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Газрын харилцаа, барилга, хот, байгуулалтын газар, Эрүүл мэндийн газар, 100900000608-МЭЕГ-ын хяналт шалгалтын орлого дансанд Мал эмнэлгийн газар гэсэн 5 байгууллага тайлант онуудад нийт 40.6 сая төгрөгийн торгууль ногдуулснаас 30.6 сая төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр тайлант онуудад 7 байгууллага 169,697 зөрчилд 6,586.7 сая төгрөгийн торгууль ногдуулсан. Үүнээс тус онуудад хамаарах 2,394.3 сая төгрөгийн торгууль бүрэн төвлөрсөн, 4,192.4 сая төгрөгийн торгууль төвлөрөөгүй, өмнөх онуудын үлдэгдлээс 4,061.4 сая төгрөгийн торгууль нөхөн төвлөрсөн байна.

Хүснэгт 5: ЭБАТ-ны ногдуулсан торгуулийн орлогын нэгтгэсэн судалгаа
(мянган.төгрөг)

Д/Д	Орлого төвлөрүүлэгч байгууллагын нэр	Он	Ногдуулсан	Зөрчлийн тоо	Үүнээс		
					Төвлөрсөн	Илүү	Дутуу
1	Төв аймгийн Татварын газар	2023 он	237,784.1	107	370,397.9	189,420.2	56,806.3
		2024 он	727,919.7	128	692,091.4	514,118.0	549,946.3
2	Төв аймгийн Цагдаагийн газар	2023 он	2,484,712.6	82,733	2,165,639.5	1,538,102.3	1,857,175.4
		2024 он	2,611,026.0	84,588	2,693,888.0	1,808,305.0	1,725,443.0
3	ГХИГ-ын АЗБХГ	2023 он	72,240.0	356	72,380.0	140.0	-
		2024 он	154,440.0	633	154,520.0	80.0	-
4	Аймгийн УБХ	2023 он	10,680.0	416	10,680.0	20.0	-
		2024 он	15,230.0	529	15,230.0	-	-
5	Аймгийн ЗДТГ СХЗХ	2023 он	44,350.0	28	44,350.0	-	-
		2024 он	137,500.0	39	137,500.0	-	-
6	Аймгийн ОБГ	2023 он	1,200.0	3	1,200.0	-	-
		2024 он	11,600.0	19	8,600.0	-	3,000.0
7	Аймгийн БОГ	2023 он	44,830.0	53	52,405.8	7,575.8	-
		2024 он	33,200.0	65	36,840.0	3,640.0	-
Аймгийн төсөвт төвлөрүүлсэн дүн		2023 он	2,895,796.7	83,696.0	2,717,053.2	1,735,258.3	1,913,981.7
		2024 он	3,690,915.7	86,001.0	3,738,669.4	2,326,143.0	2,278,389.3
1	Төв аймгийн ХХААГ	2023 он	5,466.0	15	5,466.0	-	-
		2024 он	500.0	1	500.0	-	-
2	Төв аймгийн ХХҮГ	2023 он	-	-	-	-	-
		2024 он	14,150.0	11	14,150.0	-	-
3	Төв аймгийн ГХБХБГ	2023 он	4,560.0	11	4,560.0	-	-
		2024 он	5,000.0	1	5,000.0	-	-
4	Төв аймгийн ЭМГ	2023 он	10,000.0	1	-	-	10,000.0
		2024 он	-	-	-	-	-
5	Төв аймгийн МЭГ	2023 он	500.0	4	500.0	-	-
		2024 он	450.0	4	450.0	-	-
Улсын төсөвт төвлөрүүлсэн дүн		2023 он	20,526.0	31.0	10,526.0	-	10,000.0
		2024 он	20,100.0	17.0	20,100.0	-	-
Нийт дүн		2023 он	2,916,322.7	83,727.0	2,727,579.2	1,735,258.3	1,923,981.7
		2024 он	3,711,015.7	86,018.0	3,758,769.4	2,326,143.0	2,278,389.3

Эх сурвалж: Аудитын ажлын баримт




Аймгийн ОБГ-ын 2024 онд ногдуулсан торгуулийн 74.1 хувь нь төвлөрсөн, 25.9 хувь нь төвлөрөөгүй, Татварын газрын ногдуулсан торгууль 2023 онд 76.1, 2024 онд 24.5 хувийн төвлөрсөн, тайлант онуудын нийт дүнгээр 606.8 сая төгрөгийн торгууль төвлөрөөгүй байна.

Торгуулийн орлогын 54.1-62.9 хувийг аймгийн Цагдаагийн газрын торгуулийн орлого бүрдүүлж байна. Цагдаагийн газраас 2023 онд 82,733 зөрчилд 2,484.7 сая төгрөг, 2024 онд 84,588 зөрчилд 2,611.0 сая төгрөгийн торгууль тус тус ногдуулсан байна.

Хүснэгт 6: Аймгийн Цагдаагийн газрын торгуулийн орлого
/сая.төгрөгөөр/

(Төвлөрсөн дүн:2025 оны 7 дугаар сарын 04-ний өдрийн байдлаар)



Эх сурвалж: Аудитын ажлын баримт

Б.1.2. Аймгийн хэмжээнд 23 байгууллага, 21 суманд нийт 244 ЭБАТ бүртгэлтэй байна. Үүнээс 148 ЭБАТ 2023 онд 2,895.8 сая төгрөгийн торгууль, 2024 онд 3,690.9 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна.

Б.1.3. Аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн тайланд аймгийн төвлөрсөн төсвийн торгуулийн орлогыг 2023 онд 10.6 сая төгрөгөөр, 2024 онд нийт 15.2 сая төгрөгөөр илүү тайлагнасан байна.

Хүснэгт 7: Аймгийн ТЕЗ-ийн 2023-2024 оны хүү, торгуулийн орлогын төсвийн гүйцэтгэлийн тайлангийн зөрүү

		/сая.төгрөгөөр/				
Дансны дугаар	Дансны нэр	Хуулгаар	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Буцаалт	Тайлагнах дүн нь	Илүү, дутуу тайлагнасан дүн
2023 онд						
100140000988	Тө.Хүү, торгуулийн орлого	258.88	233.52	11.1	223.8	10.6
2024 онд						
100140000982	Тө.МХГазар - орлого	440.85	440.85	10.00	430.85	10.00
100140000985	Тө.ЦХ-н хүү торгуулийн орлого	832.38	813.34	3.03	810.31	3.03
100140000988	Тө.Хүү, торгуулийн орлого	488.98	484.34	0.40	483.94	0.40

Эх сурвалж: Аудитын ажлын баримт



Дараах 11 сумдын хувьд торгуулийн орлогыг төсвийн гүйцэтгэлийн тайланд 2023 онд 12.9 сая төгрөгөөр, 2024 онд 170.44 сая төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасан байна. Бусад нэр төрлийн орлогыг торгуулийн орлогоор эсхүл торгуулийн орлогыг бусад нэр төрлийн орлогоор тайлагнажээ. Тухайлбал:

- 2023 онд
 - Борнуур сум түрээсийн орлогын¹ 4.0 сая төгрөгийг хүү торгуулийн орлогоор тайлагнасан,
 - Сүмбэр сум татварын торгууль², алданги³ дансны орлогын дүнгээр буюу нийт 6.7 сая төгрөгийг тайлагнаж, хүү торгуулийн орлогын⁴ дансны 8.3 сая төгрөгийг тайлагнаагүй,
 - Цээл сум хүү торгуулийн орлогоос 0.6 сая төгрөгийг дутуу тайлагнасан байна.
- 2024 онд
 - Батсүмбэр сум тамхины зөвшөөрлийн хураамж 0.2 сая төгрөг,
 - Баянцогт сум түрээсийн орлого 0.02 сая төгрөг,
 - Борнуур сум хүү, торгуулийн орлогоос бусад 4 нэр төрлийн орлогоор төвлөрсөн 46.1 сая төгрөг,
 - Дэлгэрхаан сум бусад нэр төрлийн орлогоор төвлөрсөн 0.7 сая төгрөг,
 - Эрдэнэ сум шүүхийн шийдвэрээр хураагдсан эд хөрөнгийн 24.9 сая төгрөгийн орлогыг хүү торгуулийн орлогын дансанд тус тус тайлагнасан.
 - Баянцагаан сум татварын алданги 87.5 сая төгрөгийг хог хаягдлын хураамжийн орлого дансанд тайлагнасан,
 - Цээл сум хүү торгуулийн орлогоос 1.1 сая төгрөгийг дутуу тайлагнасан,
 - Архуст сум төсвийн гүйцэтгэлийн тайланд хуулгаар орсон дүнгээс 0.02 сая төгрөгөөр илүү,
 - Сүмбэр сум татварын торгууль, алданги дансанд төвлөрсөн 0.4 сая төгрөгийг тайлагнаж, хүү торгуулийн орлогын 10.6 сая төгрөгийн орлогыг тайлагнаагүй байна.

Торгуулийн орлогыг эх үүсвэрээр нь ангилан, төрийн сангийн холбогдох дансанд төвлөрүүлж байгаа боловч бодит байдлаар нэг дансанд хэд хэдэн өөр төрлийн торгууль бусад орлого төвлөрч байна. Энэ нь бүртгэл, тайлагналын үнэн зөв байдалд сөргөөр нөлөөлж байна.

Өөрөөр хэлбэл иргэн, аж ахуйн нэгжүүд торгуулийн төлбөрийг шилжүүлэхдээ ихэвчлэн регистрийн дугаар, овог нэр, автомашины дугаар зэрэг ямар торгууль төлж байгаа талаар тодорхой бус утгаар гүйлгээ хийж байна. Эдгээр мэдээллүүд нь гүйлгээг тодорхойлох, ангилахад хангалтгүй ба дараах хүндрэлүүд бий болж байна. Үүнд:

- СТСХ-ийн холбогдох албан тушаалтнууд тухайн гүйлгээг ямар байгууллагын ЭБАТ ногдуулсан болохыг тодорхойлох боломжгүй,
- Ямар төрлийн торгуулийн орлого болох нь тодорхойгүй, (замын хөдөлгөөний, татварын, байгаль орчин, татварын гэх мэт)
- Бүртгэл, тайлан боловсруулах үед гараар шалгах, ангилах шаардлага тулгарч, хугацаа, нөөцийг үр ашиггүй зарцуулах.

¹ (...914) данс- Татварын бус орлого

² (...952) данс- Татварын алданги


³ (...956) данс- Татварын торгууль

⁴ (...988) данс- Хүү, торгууль



Б.1.4. Аймгийн ТЭЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар 101,163.5 сая төгрөг, 2024 оны тайлангаар 141,047.9 сая төгрөгийн нийт орлого төвлөрсөн. Үүнээс татварын бус орлогоор 2023 онд 46,016.7 сая төгрөг, 2024 онд 58,820.7 сая төгрөг тайлагнасан байна.

Хүснэгт 8: Аймгийн нийт орлого, татварын бус орлогын дүнд торгуулийн орлогын эзлэх дүн



Эх сурвалж: ТЭЗ-ийн 2023, 2024 оны санхүүгийн тайлан, аудитын ажлын баримт

Нийт орлогын дүнд торгуулийн орлогын эзлэх хувь тайлант онуудад 3.4 хувь, татварын бус орлогын дүнд торгуулийн орлогын үзүүлэх нөлөө 7.5-аас 8.3 хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл аймгийн нийт орлого болон татварын бус орлогод торгуулийн орлогын үзүүлэх нөлөө бага байна.

Б.2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд торгуулийн орлогыг хуваарилахдаа хуульд заасан хувь хэмжээг баримтлаагүй байна.

Б.2.1. Орон нутгийн төсвийн орлогыг хуваарилах чиг үүргийг аймгийн ТЭЗ болон сумдын ТТЗ хэрэгжүүлж байна. Орон нутгийн төсвийн орлогын нэг төрөл болох торгуулийн орлогыг хуваарилахад Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-т заасан Эрүүгийн хуульд заасны дагуу оногдуулсан торгох ял, Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтуудын дагуу ногдуулсан торгох шийтгэлийн дагуу хуваарилсан эсэхийг тодорхойлох боломжгүй байна.

Учир нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.2.-т “аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, ... тухайн шатны жилийн төсвийн төслийг хэлэлцэн жил бүрийн 12 дугаар сарын 05-ны дотор батлах; 8.5.4-т “сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, тухайн шатны жилийн төсвийн төслийг хэлэлцэн жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор батлах” гэж, мөн 7 дугаар зүйлийн 7.1.-т



“Төсвийн жил нь тухайн оны 01 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно” гэж заасан.

Гэтэл Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-т “...зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийг биелүүлж, төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүнгийн 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг дүрс бичлэгийн техник, хэрэгсэл, зөрчил болон эрүүгийн хэрэг хянан шалгах байгууллагын мэдээллийн нэгдсэн системийг сайжруулах ажилд, 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бусад ажилд зориулан дараагийн жилийн төсөвт тусгаж, санхүүжүүлнэ.” гэж заасан байна.

Өөрөөр хэлбэл тухайн жилийн торгуулийн орлого эцэслэн төвлөрөөгүй байх цаг хугацаанд дараагийн жилийн төсвийг баталж байгаа нь дээрх хувь хэмжээгээр бодитой төлөвлөх боломжгүй нөхцөл байдлыг үүсгэж байна.

Б.2.2, Б.2.3. Торгуулийн орлогоос ГХУСАЗ-д сумд харилцан адилгүй төсөв баталсан байна. Тухайлбал:

- Өндөрширээт сум төсөв батлаагүй,
- Аргалант сум 2023 онд төсөв батлаагүй,
- Баянжаргалан сум өмнөх оны гүйцэтгэлээр 0.9 сая төгрөгийн торгуулийн орлого төвлөрсөн байхад 2023 онд 2.0 сая төгрөг төлөвлөсөн,
- Бүрэн сум өмнөх оны гүйцэтгэлээр 0.4 сая төгрөгийн торгуулийн орлого төвлөрсөн байхад 2024 онд 4.0 сая төгрөг төлөвлөсөн байна.

Мөн Алтанбулаг, Баянжаргалан, Баянцогт, Бүрэн, Цээл сумд торгуулийн орлогын өмнөх жилийн гүйцэтгэлийн 40-с дээш хувиар ГХУСАЗ-д санхүүжилт баталсан⁵ байна.

Хүснэгт 9: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зардлын төлөвлөлтийн байдал

Ангилал	Он	Өмнөх оны торгуулийн орлогын гүйцэтгэл	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зардалд		/сая.төгрөг/ Торгуулийн орлогын дүнд эзлэх хувь
			Хуваарилах доод дүн (40%)	Батлагдсан дүн	
27 сумд	2023 он	1,158.6	463.4	137.5	11.87
	2024 он	1,816.7	726.7	289.5	15.93
Аймаг	2023 он	1,430.3	572.1	150.0	10.49
	2024 он	1,631.2	652.5	150.0	9.20

Эх сурвалж: Аймаг, сумдын 2022, 2023 оны төсвийн гүйцэтгэл, 2023, 2024 оны төсөв баталсан тогтоол

Эндээс дүгнэхэд Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-т заасан торгох шийтгэл ногдуулсан зөрчлийн нэр төрөл болон хуульд заасан хувь хэмжээгээр ангилан торгуулиас бүрдсэн орлогыг хуваарилах мөн тухайн хуулийн заалтыг бүрэн биелүүлэх боломжгүй байна.

Авто замын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2-т Нийслэл, орон нутгийн чанартай авто замын сангийн хөрөнгийг 7 эх үүсвэрээс бүрдэхээр баталсан ба үүнд орон нутгийн авто зам дээр хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргасан, авто замын талаарх хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгууль хамаарахаар байна. Аймгийн авто замын санд 2023 онд 1,200.0 сая, 2024 онд 1,500.0 сая төгрөгийн зардал тус тус баталсан байна.

⁵ Хавсралтаар харуулав.



Б.2.4. Аймгийн хэмжээнд торгуулийн орлогыг өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн, нэмэгдүүлэн төлөвлөж байгаа хэдий ч ЭБАТ нь торгуулийн орлогын нарийвчилсан төлөвлөгөө байхгүй, ногдуулсан орлогын төвлөрүүлсэн байдлыг ажил дүгнэх үзүүлэлтэд харгалздаггүй, орлогын биелэлтийг харгалзан албан хаагчдад ямарваа нэгэн төрлийн шагнал урамшуулал эсхүл хариуцлага ногдуулдаггүй байна.

БҮЛЭГ В. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН ЗАРЦУУЛАЛТЫГ ЗӨВХӨН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛААР ҮНЭЛЖ, ДҮГНЭХ БОЛОМЖГҮЙ БАЙНА.

В.1. Торгуулийн орлогын тодорхой хувийг ГХУСАХЗ-д баталж, зарцуулж байна.

В.1.1. Аймаг, сумдын хүү торгуулийн орлогыг төсвийн санхүүжилтийн дансанд төвлөрүүлэн төсвийн зарлагыг санхүүжүүлж байна. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авто замын тухай хуулиар торгуулийн орлогын тодорхой хувийг зарцуулах зохицуулалттай. Авто замын санд хуваарилсан хөрөнгийн хэдэн хувь нь торгуулийн орлогоос, хэдэн хувь нь татвар, төлбөр болон бусад хураамжаас бүрдэж байгаа нь тодорхой бус тул авто замын сангийн хөрөнгийн зарцуулалтыг энэхүү аудитын хүрээнд авч үзээгүй болно. Мөн түүнчлэн автозамын сангийн хөрөнгийн зарцуулалт орон нутгийн хөрөнгө оруулалтын аудитаар шалгагдсан. ГХУСАЗ-д аймгийн хэмжээнд 2023 онд 317.5 сая төгрөг төлөвлөж 296.0 сая төгрөг, 2024 онд 469.4 сая төгрөг төлөвлөж 445.2 сая төгрөг зарцуулжээ.

Хүснэгт 10: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл

(мянган.төгрөг)

№	Сум	ГХУСЗардал			
		2023 он		2024 он	
		төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл
1	Аргалант	-	-	2,000.0	2,000.0
2	Алтанбулаг	2,000.0	1,998.5	2,500.0	2,340.5
3	Архуст	2000.0	1,974.0	2,200.0	2,200.0
4	Батсүмбэр	3,000.0	3,000.0	8,000.0	7,996.7
5	Баян	5,000.0	4,281.4	5,000.0	4,802.4
6	Баяндэлгэр	2,000.0	1,998.0	2,000.0	1,999.9
7	Баянжаргалан	2,000.0	2,000.0	2,000.0	1,999.9
8	Баян-Өнжүүл	2,000.0	1,708.0	2,000.0	1,432.5
9	Баянхангай	5,500.0	5,500.0	5,500.0	5,500.0
10	Баянцагаан	3,000.0	2,270.0	3,000.0	2,477.2
11	Баянцогт	4,000.0	3,666.3	4,000.0	4,000.0
12	Баянчандмань	8,700.0	8,700.0	4,597.5	4,597.5
13	Борнуур	4,000.0	4,000.0	6,000.0	6,000.0
14	Бүрэн	2,200.0	2,198.3	4,000.0	3,999.8
15	Дэлгэрхаан	2,000.0	2,000.0	2,000.0	2,000.0
16	Жаргалант	14,450.0	14,450.0	13,230.0	13,230.0
17	Заамар	6,500.0	6,500.0	8,000.0	4,776.0
18	Зуунмод	6,000.0	5,999.3	12,000.0	11,997.4
19	Лүн	24,682.0	24,682.0	65,624.5	65,624.5
20	Мөнгөнморьт	9,420.0	7,134.3	6,000.0	5,988.0
21	Өндөрширээт	-	-	-	-
22	Сүмбэр	2,000.0	2,000.0	3,400.0	3,400.0



23	Сэргэлэн	4,300.0	4,300.0	26,911.0	26,911.0
24	Угтаал	2,000.0	2,000.0	3,500.0	3,000.0
25	Цээл	3,000.0	3,000.0	2,000.0	1,999.7
26	Эрдэнэ	13,750.0	11,829.9	90,000.0	87,907.0
27	Эрдэнэсант	4,000.0	4,000.0	4,000.0	4,000.0
	Сумдын дүн	135,502.0	129,216.0	287,263.0	279,980.0
28	Аймаг	150,000.0	164,814.0	150,000.0	162,986.7
	Нийт дүн	287,502.0	296,003.0	439,463.0	445,166.7

Эх сурвалж: Аймаг, сумдын ИТХ-ын тогтоол, санхүүгийн тайлан

Засгийн газрын дамжуулан зээлдүүлэх OL-1847 MON-11 OL-2301 MON-11 гэрээний дагуу 2023 онд зээлийн үндсэн төлбөрт 186.6 сая, хүүгийн төлбөрт 27.7 сая, нийт 224.4 сая төгрөг, 2024 онд OL-1847 MON-11 зээл, хүүгийн төлбөрт 20.5 сая төгрөг тус тус улсын төсөвт төлсөн байна.

В.1.2. Аймгийн ИТХ-ын төсөвт аймгийн ГХУСАЗСЗ-ийн үйл ажиллагааны зардал тусгагдаж эдийн засгийн ангилал /210901/, хөтөлбөр 70105 /82201/, арга хэмжээ /82201/ гэсэн зориулалтаар зарцуулагджээ. Аймгийн ИТХ-ын үйл ажиллагааны зардалд 2023 онд 21.0 сая төгрөгийг ГХУСАХЗ-аас шилжүүлэн зарцуулжээ.

Аймгийн ГХУСАЗСЗ нь жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө батлахдаа тухайн хэрэгжүүлэх арга хэмжээний төсөв, санхүүжилтийг тавьж, зорилт, арга хэмжээ тус бүрээр зарцуулалтыг гаргасан байна.

Хүснэгт 11: ГХУСАХЗ-ын зарцуулалт

№	Төлөвлөгөөний зорилго, чиглэл	2023 он			2024 он		
		Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ерөнхий чиглэлийн хүрээнд	5	24,000.0	20,800.0	2	14,000.0	7,950.0
2	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тусгай чиглэлийн хүрээнд	17	60,900.0	49,518.0	18	55,000.0	48,757.3
3	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэг бүрчилсэн чиглэлийн хүрээнд:	2	2,600.0	1,000.0	4	12,000.0	11,000.0
4	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх чиглэлийн хүрээнд:	4	11,500.0	11,900.0	5	43,000.0	38,880.0
5	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бусад ажил, арга хэмжээний хүрээнд	7	81,000.0	60,595.5	5	56,000.0	56,399.4
6	Аймгийн ГХУС зардлаас аймгийн ИТХ-ын үндсэн зардал руу шилжүүлсэн дүн		0.0	21,000.0		0.0	0.0
	Дүн	35	180,000.00	164,813.52	34	180,000.00	162,986.73

Эх сурвалж: Аймаг, сумдын ИТХ-ын тогтоол, санхүүгийн тайлан



Аймгийн ИТХ-ын 2023 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ ГХУСАХЗ-аас гадаад томилолтод 21.0 сая төгрөг зарцуулсан зөрчилд албан шаардлага бичиж зөрчлийг арилгуулан ажилласан.

В.1.3. Аймгийн ГХУСАЗСЗ-ийн 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 02 дугаар тогтоолоор салбар зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 13 зорилтын хүрээнд 41 арга хэмжээ хэрэгжүүлэхээр баталжээ. Жилийн эцэст төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэхэд 2 арга хэмжээ хэрэгжээгүй, 2 арга хэмжээ 70 хувийн хэрэгжилттэй, бусад арга хэмжээнүүд бүрэн хэрэгжиж, 93.0 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна.

Хүснэгт 12: Дутуу хэрэгжсэн болон хэрэгжээгүй арга хэмжээ

Арга хэмжээ	Хэрэгжилт
Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх шторк, контент болон сэрэмжлүүлэг мэдээлэл олон нийтэд түгээнэ	70 хувь "МҮОНТ" -ийн MNB мэдээний цагаар 4 удаа, "ТВ -5", орон нутгийн "ТБС", "ТӨВ" телевизээр 38, МОНЦАМЭ.mn, TV5.mn зэрэг сайтуудаар 4 удаа тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн нөхцөл байдлын талаар иргэд, олон нийтэд мэдээлэл өгч ажилласан.
"Сургуулийн бүс, техникийн ерөнхий шаардлага" стандартыг /MNS 2014:6444/ хэрэгжүүлэх ажлын хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн орчинд хяналт хийж, тохижилтод дэмжлэг үзүүлнэ	70 хувь Төв аймгийн Хүмүүн Цогцолбор сургуулын Ахлах болон Дунд сургууль, дотуур байрны бүсд гадна талбайд чанарын шаардлага хангасан нийт 6 камерыг тавьж, камержуулсан.
"Цэцэгхэн охинд тохиолдсон явдал" зохиолоор мюзикл найруулж, олон нийтэд хүргэнэ	Хэрэгжээгүй
Хууль суртачилах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх "Нээлттэй шүүх" өдөрлөг зохион байгуулна.	Хэрэгжээгүй

Эх сурвалж: Аймгийн ГХУСАЗСЗ-ийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт

Аймгийн ГХУСАЗСЗ-ийн хурлыг 2023 онд 2 удаа хийж 44 тогтоол баталж, дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Тухайлбал:

- Тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлийг бууруулах зорилгоор 4 удаагийн аян, Нэгдсэн арга хэмжээ 3, Хэсэгчилсэн арга хэмжээ-35, төв аймгийн ЕБС-ийн болон төрийн байгууллагуудын дунд болзолт уралдаан тэмцээн 3 удаа тус тус зохион байгуулсан.
- Аймгийн хэмжээнд үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөл, нөлөөлөх хүчин зүйлс, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны өнөөгийн байдлыг криминологийн шинжлэх ухааны үүднээс үнэлж, дүгнэн цаашид орон нутгийн хэмжээнд шинжлэх ухааны үр дүнд суурилсан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай санал, зөвлөмж боловсруулах зорилгоор Криминологийн судалгааг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх Монголын сангийн судалгааны багтай гэрээ байгуулсан.
- Гэмт хэрэгтэй тэмцэх тусгай чиг үүргийн байгууллагуудын албан хэрэгцээнд шаардлагатай техник, хэрэгслийг өгчээ. Аймгийн цагдаагийн газарт: Dji Дрон, DJI утасгүй микрофон WIRELESS, дүрс тогтворжуулагч, дуран сапоп, сүлжээгүй газар ажиллах Iridium утас зэрэг 14.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, согтолт тодорхойлох 10.0 сая төгрөгийн тандагч багаж, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэгт (экологи) үзлэг, шинжилгээ хийхэд шаардлагатай 19.9 сая төгрөгийн үнэ бүхий техник хэрэгсэл, камер хяналтын төвд 2.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж авч өгсөн байна.



ГХУСАЗСЗ-ийн 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 01 дугаар тогтоолоор салбар зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 13 зорилт, 37 хэрэгжүүлэх арга хэмжээтэй баталсан. Төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэхэд 5 арга хэмжээ 70 хувийн, 1 арга хэмжээ 40 хувийн хэрэгжилттэй, нийтдээ 95 хувийн биелэлттэй дүгнэгдсэн байна.

Хүснэгт 13: Дутуу хэрэгжсэн болон хэрэгжээгүй арга хэмжээ

Арга хэмжээ	Хэрэгжилт
Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх шторк, контент болон сэрэмжлүүлэг мэдээлэл олон нийтэд түгээнэ	70 хувь Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр "МҮОНТ"-ийн MNB мэдээний цагаар 4 удаа, орон нутгийн "ТБС", "ТӨВ" телевизээр 30, МОНЦАМЭ.mn сайтаар 4 удаа тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн нөхцөл байдлын талаар иргэд, олон нийтэд мэдээлэл өгч ажилласан.
Аймгийн ГХУСАЗСЗ-ийн дэргэд сурагчдын Эко клуб ажиллуулна.	70 хувь Байгаль хамгаалал, хүрээлэн буй орчны тэнцвэрт байдлын талаар Зуунмод сумын Хүмүүн цогцолбор, 5-р сургууль, 4-р сургуулийн 382 сурагчдад Экологийн цагдаагийн албанаас сургалт зохион байгуулсан. Нийт дүнгээр 807 хүнд экологийн боловсрол
Аймгийн ГХУСАЗСЗ-ийн хуралдааныг зохион байгуулна.	70 хувь Аймгийн ГХУСАЗСЗ-ийн хуралдааныг 2 удаа зохион байгуулж, хуралдуулсан.
Хууль суртачилах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх "Нээлттэй шүүх" өдөрлөг зохион байгуулна	70 хувь "Нээлттэй шүүх" өдөрлөгийн арга хэмжээг хуваарийн зохион байгуулсан.
ЕБС-ийн сурагчдын гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх хүрээнд сургалт зохион байгуулж, гарын авлага хэвлэмэл хуудас хэвлүүлнэ.	70 хувь Аймгийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг түүний үр дагаврыг ойлгуулах, мэдлэг олгох зорилгоор Зуунмод сумын ЕБС-ийн 4 сургуулиудад сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулж, 1000ш тараах материал хэвлүүлж, олгосон
"Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлье" сэдэвт төвийн бүсийн аймгуудын зөвлөгөөн зохион байгуулна.	40 хувь Аймгийн ИТХ-ын Ажлын албаны бүрэлдэхүүн 2024 оны 03 дугаар сарын 26-29-ний өдөр Дархан, Сэлэнгэ аймагт ажилласан. Зам тээврийн осол, гэмт хэрэг зөрчил, хууль бус ашигт малтмал олборлолт, малын хулгай зэрэг тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээллийг танилцуулан, урьдчилан сэргийлэх чиглэлээр санал солилцож бүсийн "Хамтарсан зөвлөл байгуулах"-аар ажиллаж байна.

Эх сурвалж: Аймгийн ГХУСАЗСЗ-ийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт

Аймгийн ГХУСАЗСЗ-ийн хурлыг 2024 онд 2 удаа хийж, 44 тогтоол, шийдвэр гарган хэрэгжүүлж, ажлын хэсэг, дэд зөвлөлүүдийн хуралдааныг зохион байгуулж, 5 удаагийн ажлын хэсэг гаргаж, ажилласан байна. Аймгийн ГХУСАЗСЗ нь 2024 онд дараах ажлыг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- ГХУСАЗСЗ 2024 онд 2 удаагийн аян, 3 удаагийн нэгдсэн арга хэмжээ, 6 удаагийн хэсэгчилсэн арга хэмжээ, 5 удаагийн уралдаан тэмцээнийг гишүүн байгууллагуудтай хамтран аймгийн хэмжээнд зохион байгуулжээ.
- Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр "МҮОНТ"-ийн мэдээний цагаар 4 удаа, орон нутгийн "ТБС", "ТӨВ" телевизээр 30, МОНЦАМЭ.mn сайтаар 4 удаа тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн нөхцөл байдлын талаар иргэд, олон нийтэд мэдээлэл өгчээ. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 110 мэдээлэл, 38 видео



шторк, зурагт постер мэдээ 55-г байршуулан орон нутгийн хандалт ихтэй цахим хаягт түгээн ажилласан байна.

- Аймгийн хэмжээнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх, иргэд, байгууллагын идэвх санаачилгыг дээшлүүлэх зорилгоор “ЗӨВ ХАНДЛАГА-ЭЕРЭГ НӨЛӨӨ” аяныг 45 хоногийн хугацаанд зохион байгуулж, 27 сум, төрийн өмчит байгууллага, хэлтэс, агентлаг нийт 60 удаагийн сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж 1200 албан хаагчдыг хамруулж, эрх зүйн мэдлэг олгосон байна.
- Авлигатай тэмцэх газартай хамтран 27 сумдын ИТХ-ын Төлөөлөгчид, Хурлын дарга, Засаг дарга нарт авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлан таниулах, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, өдөрлөг зохион байгуулж, 2024 оны аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн үр дүнд шинээр сонгогдсон 27 сумын ИТХ-ын 600 орчим төлөөлөгчид хамрагдсан байна.
- Аймгийн цагдаагийн газарт энгэрийн камер, тандагч, согтуурлын түвшин тогтоогч, бэлэн бус торгуулийн гар утас, Хурууны хээ уншигч төхөөрөмж зэрэг тоног төхөөрөмж өгсөн байна.
- Төв аймаг дахь анхан болон давж заалдах шатны Шүүхийн тамгын газарт шаардлагатай 10.0 сая төгрөгийн үнэ бүхий дэлгэц байршуулж, иргэдэд Шүүх процессыг ил тод нээлттэй үзүүлдэг болжээ.
- Аймгийн Прокурорын газартай хамтран гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөл 2023 оны мэдээллийг товхимол болгон 100ш бэлтгэн холбогдох байгууллагууд, сумдын ГХУСАЗЗ-д хүргүүлсэн байна.

Аймаг, сумдын ГХУСАЗЗ жил бүр тодорхой зорилт, арга хэмжээ бүхий төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажилласнаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр олон нийтийн хамарсан тодорхой үр дүнд хүрсэнд ажил зохион байгуулсан байна.

Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хүрээнд авто замын арчлалт хамгаалалт, замын тэмдэг тэмдэглэгээ сайжирч, явган зам нэмэгдсэнээр олон нийт үр ашгийг нь хүртэж байна.

В.1.4. Хүү, торгуулийн орлого нь дараах байдлаар зарцуулагдаж байна.

Үүнд:

1. Аймгийн дэд бүтцийг хөгжүүлэх дамжуулан зээлдүүлсэн зээлийн зээл, хүүгийн төлбөр,
2. ГХУСАХЗ,
3. Авто замын сан,
4. Төсвийн зарлагын санхүүжилт

Аймгийн хэмжээнд хүү, торгуулийн орлогоор 2023 онд 3,447.8 сая төгрөг, 2024 онд 4,875.2 сая төгрөг орсноос ГХУСАХЗ-д 2023 онд 296.0 сая төгрөг, 2024 онд 445.1 сая төгрөг зарцуулсан нь тухайн орлогын 8.6-9.1 хувийг эзэлж байна. Иймд зөвхөн ГХУСАХЗ-ын зарцуулалтаар хүү, торгуулийн орлогын зарцуулалтыг үнэлж, дүгнэх боломжгүй юм.

Дамжуулан зээлдүүлэх зээлээр аймгийн дэд бүтцийг сайжруулах ажил хийгдсэн бол ГХУСАХЗ-аар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлийн арга хэмжээ, замын сангийн санхүүжилтээр автозамын засвар арчлалт гэхчлэн орон нутгийн нийгэм эдийн засагт нөлөө үзүүлэх арга хэмжээг санхүүжүүлсэн байна.



В.2. Торгуулийн орлогын зарцуулалтыг шилэн дансны нэгдсэн системээр дамжуулан олон нийтэд ил тод мэдээлж байна.

В.2.1. Аймаг, сумдын Засаг дарга нар тухайн жилийн орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын гүйцэтгэлийн мэдээг Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2.5-д заасны дагуу шилэн дансны сайтад улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл гэсэн цэсэд сар бүр мэдээлж ажилласан байна. ГХУСАХЗ, автозамын сангийн зарцуулалтыг Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-н 6.3.1, 6.3.2-д заасны дагуу тогтоосон хугацаанд мэдээлсэн байна.

В.2.2. Төсвийн тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.3 дахь хэсэгт “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Зөвлөлөөс баталсан тухайн жилийн төсвийг ил тод, олон нийтэд хүртээмжтэй байдлаар мэдээлнэ” гэж заасан байна. Аймаг, сумдын ИТХ 2023-2024 онд хэрэгжүүлсэн ажлын тайлан, мэдээллийг аймаг, сумдын “иргэдийн Төлөөлөгчдийн хурал” болон “ГХУСАЗСЗ”-ийн цахим сайт болон социал мэдээллийн хуудсаар дамжуулан иргэд олон нийтэд мэдээлж ажилласан байна. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, автозамын сангийн зарцуулалтыг шилэн дансанд мэдээлсэн байна.

В.2.3. Хүү, торгуулийн орлогын зарцуулалттай холбоотойгоор иргэд, төрийн бус байгууллага, хяналтын зөвлөл зэрэг оролцогч талуудаас албан ёсны үнэлгээ, санал, дүгнэлт гаргаж байгаагүй байна.

БҮЛЭГ Г. ТОРГУУЛЬ НОГДУУЛАХ ЭРХ БҮХИЙ ИХЭНХ БАЙГУУЛЛАГУУДАД МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН БАЙХГҮЙГЭЭС, ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ХҮНДРЭЛТЭЙ БАЙНА.

Г.1. Хүү, торгуулийн орлого бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сан хангалтгүй байна.

Г.1.1. Аймгийн Цагдаагийн газар нь зөрчлийн талаарх мэдээллийг Цагдаагийн ерөнхий газрын Мэдээллийн нэгдсэн системд бүртгэдэг. Харин Прокурорын байгууллага нь уг систем дэх бүртгэл, мэдээлэл, зөрчлийн хэргийн шийдвэрлэлт зэрэгт хяналт тавьж ажилладаг.

Мөн Татварын газар нь Татварын удирдлагын нэгдсэн системийг ашиглан торгуулийн орлогыг ногдуулж, нэхэмжлэлд суурилсан төлбөрийн бүртгэлийн системийг хэрэглэж байна.

Торгууль ногдуулах эрх бүхий бусад байгууллагуудын хооронд мэдээлэл солилцох, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан бүрдээгүй байна. Үүний улмаас зөрчлийн мэдээлэл болон торгуулийн төлбөрийн бүртгэлийн уялдаа хангалтгүй, системчлэгдээгүй байна.

Г.1.2. Иргэд банкны цахим систем, E-Mongolia, Гэрэгэ, И баримт, Смарткар зэрэг цахим платформ ашиглан торгуулийн төлбөрийг барагдуулж байгаа боловч Цагдаагийн газраас бусад байгууллагад бүртгэлийн нэгдсэн систем бүрдээгүй тул торгууль төлөгдсөн талаарх мэдээлэл нь шууд, автомат байдлаар дамждаггүй байна.



Мөн ЭБАТ нь торгуулийн орлого төвлөрүүлж буй дансны мэдээллийг холбогдох санхүү төрийн сангийн хэлтсээр дамжуулан авах, зөрчил гаргагч иргэн, ААН-ээс ирүүлсэн төлбөрийн баримт зэргээр төлөлтийг баталгаажуулж, зөрчлийн хэрэг, шийтгэлийн хуудсанд хавсаргах байдлаар бүртгэж байна. Энэ нь төлбөр баталгаажилт удаашрах, баримтын зөрүү гарах, зөрчлийн хэргийн баримтын бүрдэл удаашрах зэрэг хүндрэл, бэрхшээлийг учруулж байна.

Г.1.3. Торгуулийн орлогын бүрдүүлэлтэд хяналт тавих тогтолцоо бүрдээгүй, тухайлсан хяналт тавих механизмыг зохицуулаагүй, торгууль ногдуулсан ЭБАТ нь зөрчлийн баримтыг бүрдүүлж, баримтжуулж байгаа тул торгуулийн орлогын барагдуулалт хангалтгүй, удааширч байна.

Ялангуяа Цагдаагийн газраас бэлэн бусын торгууль буюу төхөөрөмжөөр торгохдоо тээврийн хэрэгсэл дээр торгуулийг бүртгэдэг. Зөрчил гаргагч иргэд (жолооч) нь тухайн тээврийн хэрэгслийг худалдан борлуулах, бусдад шилжүүлэхдээ торгуулийг төлж барагдуулдгаас тухайн жилд ногдуулсан торгуулийн орлого бүрэн барагдахгүй үлдэгдэл өндөртэй байна. Үүнд тавих хяналтын тогтолцоо бүрдээгүй байна.

Г.2. Торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт хэрэгжүүлэх механизм байхгүй байна.

Г.2.1. Торгууль ногдуулах ЭБАТ-ны хуудсаар ногдуулж буй торгуулиуд нь хугацаа хэтрэлт багатай, тухайн цаг хугацаандаа төвлөрч байна. Харин торгуулийн орлогын дийлэнх хувийг эзэлж буй Цагдаа болон татварын торгууль бэлэн бусаар буюу нэхэмжлэх, цагдаагийн багажаар торгож, биелэлтийг тухайн цаг хугацаанд нь хянах боломжгүй тул хугацаа хэтрэх гол шалтгаан болж байна.

Торгуулийн орлогыг дутуу төвлөрүүлсэн байдал

(2024.12.31-ний байдлаар, сая төгрөг)

Д/Д	Торгууль ногдуулсан байгууллагын нэр	Он	Ногдуулсан	Зөрчлийн тоо	Үүнээс		
					Төвлөрсөн	Илүү	Дутуу
1	Төв аймгийн Татварын газар	2023 он	237.8	107	370.4	189.4	56.8
		2024 он	727.9	128	692.1	514.1	549.9
	Дүн		965.7	235.0	1,062.5	703.5	606.8
2	Төв аймгийн Цагдаагийн газар	2023 он	2,484.7	82,733	2,165.6	1,538.1	1,857.2
		2024 он	2,611.0	84,588	2,693.9	1,808.3	1,725.4
	Дүн		5,095.7	167,321.0	4,859.5	3,346.4	3,582.6
	Нийт		6,061.4	167,556.0	5,922.0	4,049.9	4,189.4

Эх сурвалж: Аудитын ажлын баримт

Татварын газраас тайлант онуудад төвлөрсөн 1,062.5 сая төгрөгийн орлогоос 359.0 сая төгрөгийн орлого нь тухайн онуудад хамаарах бөгөөд 703.5 сая төгрөгийн орлого нь өмнөх онуудад ногдуулсан торгуулиуд барагдсан байна.

Харин Цагдаагийн газраас тайлант онуудад төвлөрсөн 5,922.0 сая төгрөгийн орлогоос 1,732.6 сая төгрөгийн орлого нь тухайн онуудад хамаарах бөгөөд 4,189.4 сая төгрөгийн орлого нь өмнөх онуудад ногдуулсан торгуулиуд барагдсан байна.



Өөрөөр хэлбэл тайлант онуудад ногдуулсан Татварын газрын 965.7 сая төгрөгийн торгуулиас 606.8 сая төгрөг буюу 62.8 хувь дутуу, Цагдаагийн газрын 6,061.4 сая төгрөгийн торгуулиас 3,582.6 сая төгрөг буюу 59.1 хувь нь төвлөрөөгүй байна.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.2 дугаар зүйлийн 8-д “Эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан шийдвэрийг хүчингүй болгох, өөрчлөх үндэслэлтэй гэж үзвэл прокурор дүгнэлт бичиж шүүхэд хүргүүлнэ.” гэж, 7.5 дугаар зүйлийн 8-д “Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд тогтоосон хугацаанд шийдвэрийг биелүүлээгүй бол шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар албадан гүйцэтгүүлэхээр эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн 7.7 дугаар зүйлд заасан харьяалах шүүхэд хүсэлт гаргана” гэж тус тус заасан. Төв аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 2.1 дүгээр дугаар зүйлд заасан оролцогчийн гомдол ирээгүй, прокурорын дүгнэлтээр тайлант онуудад 1536 зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэсэн байна.

Зөрчлийн хэргийг шүүхээр хянан шийдвэрлэсэн судалгаа

Д/Д	Зөрчил шүүхээр хянан шийдвэрлэсэн үндэслэл	Зөрчлийн хэргийн тоо		Шүүхийн шийдвэрийн төрөл							
				Шийтгэлийг хэвээр үлдээх		Шийтгэлийг өөрчлөх		Шийтгэлээс чөлөөлөх		Шийтгэлийг хүчингүй болгох	
		2023 он	2024 он	2023 он	2024 он	2023 он	2024 он	2023 он	2024 он	2023 он	2024 он
1	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.2 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасан прокурорын дүгнэлт	300	1236	16	0	131	298	0	0	153	938
Нийт дүн		300	1236	16	0	131	298	0	0	153	938

Эх сурвалж: Төв аймаг дахь Шүүхийн тамгын газрын албан бичиг

Г.2.2. Хэдийгээр ЭБАТ-ны ногдуулсан торгуульд Прокурорын байгууллагаас хяналт тавьж, байгаа ч торгуулийн орлогын бүрдүүлэлтэд тавих хяналтын тогтолцоо байхгүй. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.5 дугаар зүйлийн 1-д “Эрх бүхий албан тушаалтан шийтгэл оногдуулсан, албадлагын арга хэмжээ авсан шийдвэрийнхээ биелэлтийг хариуцна.” гэж заасан. Иймд торгуулийн орлогын бүрдүүлэлтэд хяналт хэрэгжүүлэх систем бүрдээгүй, хяналтын тогтолцоо байхгүй байна.

Сумдын ГХУСАЗСЗ-ийн тайланг аймгийн салбар зөвлөлд жилийн эцсээр тайлагнаж байгаа ч ГХУСАХЗ-ын гүйцэтгэлд тухайлсан хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Г.2.3. Торгууль ногдуулах эрх бүхий байгууллагууд шийтгэлийн хуудасны тооцоо хариуцсан албан хаагчаар ихэвчлэн нягтлан бодогчийг хариуцаж байна. Тухайн нягтлан бодогч нь аймгийн ЗДТГ-ын санхүү, төрийн сангийн хэлтсийн шийтгэлийн хуудасны бүртгэл, мэдээлэл хариуцсан албан хаагчаас шийтгэлийн хуудсыг авч бүртгэн, тулгалт, тооцоо хийж, зарцуулалтыг тайлагнаж байна.



Шийтгэлийн хуудасны бүртгэл мэдээллийг тулган шалгахад ГИХГ-аас ногдуулсан 8 торгуулийн шийтгэлийн хуудас бүртгэгдээгүй, зөрүүтэй байна. Иймд СТСХ-т шийтгэлийн хуудасны бүртгэлийг биет байдлаар тулган шалгаж байх зөвлөмж хүргүүлэв.

Мөн ЭБАТ-тай шийтгэлийн хуудасны мэдээлэл, тооцоог нийлүүлэн зарцуулалтад хяналт тавьж ажилладаг. Гэсэн хэдий ч торгуулийн орлого бүрдүүлэлт, бүртгэлийн үйл ажиллагаанд аудитад хамрагдагч байгууллагууд дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Г.2.4. Иргэд, Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага зэрэг хөндлөнгийн байгууллагуудаас торгуулийн орлого бүрдүүлэлт, зарцуулалтад 2023-2024 онуудад хяналт хэрэгжүүлээгүй байна.



ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

- Хүү, торгуулийн орлогыг хууль болон журмын хүрээнд төлөвлөсөн байна.
- Өмнөх жилүүдэд эрх бүхий байгууллага, албан тушаалтны тавьсан торгууль, акт, алданги, хохирол нөхөн барагдуулалт, тухайн жилийн ногдуулалт, дутуу төлөлт зэргийг нарийвчлан тооцсон тооцоо, судалгаа байхгүй, хүү, торгуулийн орлогын төлөвлөлтийг өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн хийж байна.
- Торгуулийн орлого бүрдүүлэлттэй холбоотой гол эрх зүйн актууд болох Зөрчлийн хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл, заалтад дүн шинжилгээ хийж сайжруулах хэрэгцээ шаардлага байна.
- Тайлант онуудад торгуулийн орлого төлөвлөгөөнөөс давж биелж байгаа ч тухайн онд ногдуулсан торгуулийн орлогын биелэлт хангалтгүй байна.
- Торгуулийн орлогыг зориулалтын дагуу зарцуулсан эсэхийг үнэлж, дүгнэх боломжгүй байна.
- Зарцуулалтыг шилэн дансны нэгдсэн системээр дамжуулан олон нийтэд ил тод мэдээлсэн байна.
- Аймгийн болон зарим сумдын төсвийн гүйцэтгэлийн тайланд торгуулийн орлогыг зөрүүтэй тайлагнасан байна.
- ЭБАТ-ны ногдуулсан торгуулийг бүртгэх, хянах, мэдээллийн систем хангалтгүй байна.
- Зөрчил ногдуулж буй шийтгэлийн хуудсыг бүртгэж байгаа хэдий ч биет байдлаар тоолж, тулган баталгаажуулаагүй байна.



ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт, нотлох зүйлд үндэслэн аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дарга Ю.Бямбацогт, мэргэжилтэн Н.Хорлоо нарт зөвлөх нь:

- Эрх бүхий байгууллага, албан тушаалтны тавьсан торгууль, акт, алданги, хохирол нөхөн барагдуулалт, дутуу төлөлтийн судалгаатай болж, төсвийн төлөвлөлтөд ашигладаг болох,
- Торгуулийн орлогыг төсвийн гүйцэтгэлийн тайланд үнэн зөв тайлагнах, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэж буй сумдын төсвийн гүйцэтгэлийн тайланд тавих хяналтыг сайжруулах,
- Шийтгэлийн хуудсыг биет байдлаар тулган шалгаж, тооцоог баталгаажуулах

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ УЛАМЖЛАХ, НЭГДСЭН ТАЙЛАНД ОРУУЛАХ САНАЛ:

- Зөрчлийн хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл, заалтад дүн шинжилгээ хийж, эрх зүйн орчныг сайжруулах зөвлөмжийг холбогдох газарт өгөх.
- Эрх бүхий байгууллагуудын хооронд торгуулийн мэдээллийн нэгдсэн санг үүсгэх, бүртгэл, тайлагналын систем хэрэгжүүлэх, улмаар төлбөрийн мэдээлэл дамжуулах автомат механизмыг хөгжүүлэх

Тайлан хянасан:

Дарга, Тэргүүлэх аудитор

Ц.Хишигжаргал

Аудитын менежер

О.Амаржаргал

Тайлан бичсэн:

Ахлах аудитор

Л.Жаргалсайхан

Аудитор

Г.Сугармаа



Холбогдох байгууллагын санал:


**ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗАР**


41111 Төв аймаг, Зуунмод сум, Номт 1 дүгээр баг
Утас: 70273623, И-мэйл: tuv_xdtg@tov.gov.mn

2025. 08. 07 № 05/1506

танай _____-ны № _____-т

Г ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
Ц.ХИШИГЖАРГАЛ ТАНАА

Хүү торгуулийн орлогын бүрдүүлэлт,
зарцуулалтад хийсэн аудитын тайлангийн төсөлтэй
танилцлаа Тайлангаар өгсөн дүгнэлт, зөвлөмжийг
хэрэгжүүлж ажиллах болно.

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА  Ю.БЯМБАЦОГТ



4125021379



ТӨВ АЙМГИЙН ТАТВАРЫН ГАЗАР
Төв, Зуунмод, 1-р баг, Номт, Өөрийн байранд
Утас: 70273869, Факс: 70273869
Цахим шуудан: tuv@mta.gov.mn
Цахим хуудас: Төв аймгийн Татварын газар

2025.08.08 № 1/357
танай _____-ны № _____-т

Г ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР Г

Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хийсэн гүйцэтгэлийн аудиттай бүрэн танилцаад санал нийлж байна.



Төв аймгийн татварын газар
Удирдлага
Дарга
Дашдондог Мөнх-учрал
2025-08-08 14:13:21



Хавсралт

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зардал баталсан дүн, хувь хэмжээ
(мянган.төгрөг)

№	Сумдын нэрс	Хүү торгуулийн орлогын гүйцэтгэл		Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зардалд батлагдсан дүн		Торгуулийн орлогын дүнд эзлэх хувь	
		2022 он	2023 он	2023 он	2024 он	2023 он	2024 он
1	Аргалант	17,356.7	40,022.5	-	2,000.0	-	5.0
2	Алтанбулаг	2,120.0	5,705.0	2,000.0	2,500.0	94.3	43.8
3	Архуст	457.9	715.0	2,000.0	2,200.0	436.8	307.7
4	Батсүмбэр	17,478.3	22,278.4	3,000.0	8,000.0	17.2	35.9
5	Баян	27,196.1	52,101.3	5,000.0	5,000.0	18.4	9.6
6	Баяндэлгэр	8,691.6	2,748.2	2,000.0	2,000.0	23.0	72.8
7	Баянжаргалан	892.6	2,079.2	2,000.0	2,000.0	224.1	96.2
8	Баян-Өнжүүл	2,350.5	12,754.9	2,000.0	2,000.0	85.1	15.7
9	Баянхангай	32,294.0	50,189.5	5,500.0	5,500.0	17.0	11.0
10	Баянцагаан	7,360.6	100,460.0	3,000.0	3,000.0	40.8	3.0
11	Баянцогт	4,328.0	6,896.5	4,000.0	4,000.0	92.4	58.0
12	Баянчандмань	207,017.4	338,602.1	8,700.0	4,597.5	4.2	1.4
13	Борнуур	47,565.5	38,962.0	4,000.0	6,000.0	8.4	15.4
14	Бүрэн	425.3	355.0	2,200.0	4,000.0	517.3	1,126.8
15	Дэлгэрхаан	537.8	-	2,000.0	2,000.0	371.9	0
16	Жаргалант	47,941.3	32,275.8	14,450.0	13,230.0	30.1	41.0
17	Заамар	38,516.6	70,065.4	6,500.0	8,000.0	16.9	11.4
18	Зуунмод	296,804.2	309,673.5	6,000.0	12,000.0	2.0	3.9
19	Лүн	234,558.3	382,768.3	24,682.0	65,624.5	10.5	17.1
20	Мөнгөнморьт	3,960.0	49,014.1	9,420.0	6,000.0	237.9	12.2
21	Өндөрширээт	1,085.2	2,295.0	-	-	-	-
22	Сүмбэр	5,691.3	6,668.4	2,000.0	3,400.0	35.1	51.0
23	Сэргэлэн	15,626.0	137,494.9	4,300.0	26,911.0	27.5	19.6
24	Угтаал	9,798.1	4,684.0	2,000.0	3,500.0	20.4	74.7
25	Цээл	6,496.0	4,437.8	3,000.0	2,000.0	46.2	45.1
26	Эрдэнэ	80,102.1	95,504.0	13,750.0	90,000.0	17.2	94.2
27	Эрдэнэсант	41,950.4	47,903.3	4,000.0	4,000.0	9.5	8.4
	сум дүн	1,158,601.8	1,816,654.3	137,502.0	289,463.0	11.9	15.9
28	Аймаг	1,430,334.0	1,631,165.3	150,000	150,000	10.5	9.2
	Нийт дүн	2,588,935.9	3,447,819.5	287,502.0	439,463.0	11.1	12.7



Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273465
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn